



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

[2021](#) оны [12](#) сарын [17](#) өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, тогтвортой хөгжлийн бодлого, хөтөлбөрт” гэснийг “холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “төрөөс баримтлах бодлого, төсөл, хөтөлбөр,” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР